



ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙ

Түгээлт:
ЕРӨНХИЙ

A/HRC/4/27
2007 оны 1 сар

Эх хувилбар:

АНГЛИ

ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛ

Дөрөв дэх ээлжит чуулган

Хэлэлцэх асуудлын 2 дугаар зүйл

**НЭГДСЭН ЧУУЛГАНЫ 2006 оны 3-р сарын 60/251 дүгээр тогтоолын хэрэгжилтийн тухай
“ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛ”.**

**Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, хамгаалах асуудлаарх тусгай илтгэгч
Амбейн Лигабогийн илтгэл
(товчилсон албан бус орчуулга)**

В. Интернэтийн засаглал ба цахим ардчилал

38. Интернэтийг хүний эрхийн хатуу байр сууринаас удирдах олон улсын байгууллагыг бий болгох нь НҮБ болон олон улсын хамтын нийгэмлэгийн тэргүүлэх зорилгын нэг юм. Интернэтийг ардчилсан үзэл бодлоо илэрхийлэх хэрэгсэл болгон тогтвортой хөгжүүлэхэд чиглэсэн олон улсын дүрэм, журам нь орчин цагт хүний эрхийг сурталчлах, хамгаалахад зайлшгүй шаардлагатай. Энэхүү байгууллага нь улс орнуудын холбогдох байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөлөгчидтэй хамтран Интернэтийн хөгжил, хэрэглээг тодорхойлох нийтлэг зарчим, хэм хэмжээ, дүрмийг боловсруулж, хэрэгжүүлэх юм
39. Зарим орны засгийн газраас энэ чиглэлээр ажилладаг үндэстэн дамнасан корпорациудын идэвхтэй дэмжлэгтэйгээр янз бүрийн хэлбэрийн эсэргүүцэл, шүүмжлэлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор вэб орчныг анхааралтай ажиглаж байна. Жирийн иргэд цахим шуудангаар эсвэл цахим хуудсаар дамжуулан үзэл бодлоо илэрхийлж зориглосны төлөө л эрх баригчид баривчлагдаж, дарамтлуулж байна.
40. Засгийн газраас хэрэгжүүлж буй улс төрийн хэлмэгдүүлэлт нь Интернэт дэх үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтын зөвхөн нэг хэсэг юм; үүний зэрэгцээ илүү нарийн зохион байгуулалтай, нууцлаг хэлбэр, агуулга бүхий нөлөөллийн ажиллагаа явагдсаар байна. Дэлхий даяарх дижитал медиа системийн хөгжлийн асуудлыг зөвхөн хүчирхэг хэвлэл мэдээллийн бүлэглэл, ашиг орлогын төлөөх арилжааны хүчний гарт үлдээх боломжгүй юм. Дижитал ертөнцийг зөвхөн бизнесийн зорилгоор хөгжүүлэх нь Интернэтээр дамжуулан хийж болох бусад бүх үйл ажиллагааны оршин тогтнолд ихээхэн аюул учруулж болзошгүй юм (жишээлбэл сурталчилгааны сонирхол давамгайлсны улмаас).
41. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хүн төрөлхтний бүхий л үйл ажиллагаанд шууд хамаатай учир арилжааны талбар нийгэм, соёлын төслүүдтэй зэрэгцэн оршдог дижитал ертөнцийг бий болгож, аливаа үйлчилгээнд хэрэглэгчид төлбөр төлөхөөс зайлсхийх боломжийг Интернэт засаглалаар баталгаажуулбал зохино. Харамсалтай нь ашгийн төлөөх сурталчилгаа цахим ертөнцөд ноёрхож, хэрэглэгчдэд чиглэсэн технологийг хөгжүүлэхдээ нэн ялангуяа залуучуудыг гол байгаа болгон түрэмгийлж байна. Цаашилбал, цахим орчин дахь мэдээллийн хэрэглээний үл мөрийг хадгалж, арилжааны зорилгоор цуглуулж буй нь хувийн нууцыг зөрчиж, улмаар Интернэтийн байнгын хэрэглэгчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж байна.
42. Интернэт хэрэглэгчдийн холбоод эдгээр чиг хандлагад хариу үйлдэл үзүүлж байгаа нь ойлгомжтой: онлайн хэрэглэгч, блогчид болон интернэтийн эрх чөлөөг дэмжигчид сүлжээний хамгаалалтыг сайжруулах чиглэлээр ажиллаж байна. Мөн Интернэт нь зөвхөн арилжааны ашиг сонирхолд үйлчлэх төдийгүй орон нутаг, дэлхийн хэмжээнд сайх сайхныг бүтээх, хөгжүүлэхтэй холбоотой асуудлаар яриа хэлэлцээ, чөлөөт мэтгэлцээн өрнүүлэх чөлөөт мэтгэлцээний суваг байх ёстой хэмээн үзэж, энэ чиглэлд хүчин зүтгэж байна. Арилжааны үйл ажиллагаа дижитал ертөнцийг зарим хэсгийг эзлэх нь тодорхой хэдий ч, хувийн аж ахуйн нэгж, байгууллагуудын хамтын ажиллагаа нь дижитал контентын хөгжлийн гол цөм байх болно.
43. Хөгжиж буй орнуудад өргөн зурвасын сүлжээг хөгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн дэмжлэгийг хангахын тулд (дээр дурдсан) олон улсын байгууллагын

оролцоо нэн чухал. Олон улсын хамтын нийгэмлэг иргэд хоорондын дижитал ялгааг бууруулах боломжийг алдах ёсгүй бөгөөд үүнд бүх хүчин чармайлтаа зориулах ёстой. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нэмэгдүүлэх энэхүү боломж нь харилцаа холбооны салбарт бизнесийн шинэ боломжуудыг бий болгосноор хүний бусад олон эрхийг, тэр дундаа эдийн засгийн эрхийг автоматаар сайжруулах болно.

С. Гүтгэлийн хэргийг эрүүгийн хуулиар шийдвэрлэхгүй байх тухай

44. Үзэл суртал, улс төрийн зүтгэлтэн, нийгэм, эдийн засгийн оролцогчидтой холбоотой асуудал дэвшүүлэх эрэн сурвалжилсан судалгаа хийх нь хууль ёсны бөгөөд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эрхийн чухал бөгөөд салшгүй хэсэг юм. Хувь хүний хувийн амьдрал, шашин шүтлэг, гэр бүл гэх мэт дотоод итгэл үнэмшил, үнэт зүйлд халдах нь илүү маргаантай байдаг. Үүнтэй адилаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тохуурхах, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах зэрэг ялгаварлалын бусад хэлбэрийг тэвчиж болохгүй.
45. Хэвлэл мэдээллийн ажилтнуудын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэх нь зөв шүүлт, оновчтой байдал, хариуцлагын мэдрэмжийг шаарддаг. Шашны гүн гүнзгий мэдрэмжийг доромжилсон хэвшмэл ойлголт, нэр хоч өөх, доромжлох нь нийгмийн янз бүрийн бүлгийн хооронд бүтээлч яриа хэлэлцээ өрнүүлэх таатай орчныг бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлдөг. Үзэл бодлын туйлшрал нь үндэстэн ястан хоорондын зөрчилдөөн бий болгож шашны үзэн ядалтыг дэлгэрүүлж, улмаар нийгэм, соёлын нарийн тэнцвэрт байдал, олон үндэстний эв нэгдэлтэй нийгэмд аюул учруулдаг.
46. Олон улсын эрх зүйн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахдаа дараах гурван нөхцөлийг нэгэн зэрэг хангах ёстой. а) Хязгаарлалтыг хуулиар тогтоосон байх ёстой, (б) тэдгээр (хязгаарлалт) нь хууль ёсны гэж хүлээн зөвшөөрөгдсөн зорилгыг хэрэгжүүлэх ёстой, мөн (в) тухайн зорилгыг биелүүлэхэд зохистой байх, ялангуяа хязгаарлах арга хэмжээний үргэлжлэх хугацааны хувьд. Бусдын эрх, нэр хүндийг хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах нь мэдээжийн хэрэг зүй ёсны зорилго боловч нэмэлт саад бэрхшээл үүсгэхгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах, дэмжих явдал нь нэмэлт бэрхшээлийг үүсгэдэг. Ихэнх тохиолдолд гүтгэлгийн гэх хэргүүд улс төр, эдийн засгийн эрх мэдэлтнүүдийн буруу үйл ажиллагааг илчлэх, авлига хээл хахуулийн эсрэг хариу арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн хараат бус байдалд зүй бус дарамт үзүүлэх зэргийг нуун дарагдуулах оролдлого байдаг.
47. Дараах тохиолдолд мэдээллийг гүтгэлэг хэмээн үзэж болно: Тухайн мэдээллийг аман яриа, бичгээр, зурагтай эсвэл дохио зангаагаар хэвлэн нийтэлсэн байх ёстой. Гүтгэлэг хэмээн тодорхойлсон зураг, видео клип, кино гэх мэт бичмэл болон зурган мэдэгдлүүд нь аман ярианаас илүү удаан үргэлжилдэг тул илүү ноцтой гэмт хэрэгт тооцогддог. Тухайн мэдээллийн агуулга бүхэлдээ худал байх ёстой. Түүнчлэн уг мэдээлэл хор хохиролтой байх ёстой – хор хохиролгүй гүтгэлэг гэж байхгүй. Эцэст нь бүх хүнд ижил тэгш үйлчлэх ёстой: тодорхой ангиллын хүмүүс илүү өртөх, жишээлбэл ажил мэргэжлийн хүрээнд мэдээлэл хийсний төлөө шүүхэд дуудагдах ёсгүй. Эцэст нь хэлэхэд, тухайн худал мэдээллийг хохироох зорилгоор, санаатайгаар түгээсэн байх ёстой. Улс, орнууд өөрийн хууль тогтоомжоор үг хэлэх эрх чөлөөг хязгаарлахдаа эдгээр нийтлэг хэм хэмжээг харгалзах ёстой бөгөөд энэ нь хэвлэл мэдээллийн ажилтнууд болон жирийн иргэдтэй холбоотой хэргүүдэд нэгэн адил хамаарна.
48. Энэ үүднээс авч үзвэл, ийм төрлийн зөрчил гарсан тохиолдолд төрөөс зохицуулах ёстой гэсэн үзэл баримтлалаас аажмаар татгалзаж, холбогдох чиглэлээр мэргэшсэн бие даасан байгууллагуудаар (хэвлэлийн зөвлөл, хэвлэлийн омбудсман) шийдвэрлүүлэх механизмд шилжих нь зүйтэй. Эдгээр байгууллага зөрчлийн ноцтой байдлыг шударгаар үнэлж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үндсэн үнэт

зүйлсийг эрсдэлд оруулахгүйгээр шийдвэр гаргах болно. Шүүхээр асуудлыг шийдвэрлэх боломжтой боловч гүтгэлгийн гэмт хэрэгт хорих ял, хэт их хэмжээний торгууль ногдуулахаас нь бүрэн татгалзах нь зөв юм.

49. Гүтгэлгийн тухай хууль тогтоомжтой холбоотой засгийн газруудын хандлага нь ихэвчлэн хоёрдмол утгатай байна. Тодруулбал, гүтгэлгийг эрүүгийн хуулиар шийдвэрлэхээс татгалзах хандлага түгээмэл болж байгаа хэдий ч хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүмжлэх эрх чөлөөг аль болох хяналтад байлгахыг зорьж буй нь харагдаж байгаа юм. Чухамдаа хэд хэдэн улс гүтгэлгийн тухай хууль тогтоомжийг шинэчилж, хүчингүй болгосны зэрэгцээ өмнө нь гүтгэлгийн хэрэг гэж үзэж байсан тохиолдлуудыг “худал мэдээлэл” хэмээн ангилах хэм хэмжээг нэвтрүүлсэн.
50. Үүний зэрэгцээ төрийн байгууллагууд гүтгэлгийн талаар өөр өөр ойлголттой байгаагийн улмаас нэгдмэл бодлого, үйл ажиллагаа явуулдаггүй. Ер нь хэд хэдэн улс оронд хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэлтнүүд ялын хүнд байдлыг бууруулах тухай шинэ хэм хэмжээг хүлээн зөвшөөрөх хандлагатай байхад хууль, шүүхийн байгууллагууд хэвлэл мэдээллийн ажилтнуудад хорих ял оноох талыг баримталсаар байна. Бусад улсад, ялангуяа хараат бус шүүх засаглалтай орнуудад шүүх нь гүтгэлгийн хэргийг шүүн хэлэлцэхдээ зөөлөн хандаж байна.
51. Харамсалтай нь сэтгүүлчдийг гүтгэсэн хэргээр хорих, их хэмжээний торгууль ногдуулах, эсвэл холбогдох хэвлэл мэдээллийн хэрэгслийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх нь нийтлэг хэвээр байгаа бөгөөд ялангуяа бие даасан сэтгүүлч, дунд болон жижиг хэвлэл мэдээллийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд, цаашлаад хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд ноцтой саад учруулж байна. Олон оронд шоронд хоригдож буй сэтгүүлчдэд жирийн гэмт хэрэгтэн мэт ханддаг бөгөөд улс төрийн зүтгэлтэн, эрх мэдэлтэй нягт холбоотой хүмүүсийг шүүмжлэхээс сэргийлэхийн тулд урьдчилан хорих арга хэмжээг өргөнөөр ашиглаж байна.
52. Улс төрийн болон олон нийтийн зүтгэлтнүүд, тэр дундаа хэвлэл мэдээллийн эзэд сэтгүүлчдийг шүүхэд өгсөөр байгаа. Гэтэл хүлээсэн үүрэг хариуцлагынхаа дагуу олон нийтийн хяналт, шүүмжлэлийг жирийн иргэнээс илүү хүлээж авахад бэлэн байх ёстой. Улс төрийн элитүүдийн ил тод байдлыг нэмэгдүүлэх нь олон чухал асуудлаар илэн далангүй, үндэслэлтэй мэтгэлцээнийг сэргэлдөөнгүйгээр өрнүүлэхэд тус дэм болох юм.
53. Хувь хүний хувийн амьдралд халдах нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах явдалтай нийцэхгүй бөгөөд үүнд нийгмийн анги, давхарга хамаарахгүй. Хувийн нууцыг хамгаалах нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бүрэн хангахад онцгой үүрэг гүйцэтгэдэг. Учир нь хувь хүний амьдралын хамгийн эмзэг хүрээг хамгаалах замаар хүн бүр бусдын тохуурхал, ялгаварлалаас айхгүйгээр эрхээ эдлэх боломжтой.
54. Өөр нэг анхаарал татсан хандлага бол хувь хүнийг гүтгэх тухай ойлголтыг гүтгэх, гутаан доромжлоход хамаарах нийтлэг үнэт зүйлтэй холих оролдлого юм. Эдгээр үнэт зүйлд үндэсний өвөрмөц байдлын мэдрэмж, төрийн далбаа, төрийн дуулал зэрэг төрийн бэлгэдэл, дээд шүүх, тухайн улсын эцэг(үүд) эсвэл ерөнхий сайд гэх мэт төрийн байгууллага, албан тушаалтан, төлөөлөгчид багтааж, “Төрийг гутаан доромжлох” хэмээн томъёолж байна. Үүнтэй холбогдуулан түүхэн үйл явдлуудыг судлахад үг хэлэх эрх чөлөө үргэлж хангагдах ёстойг Тусгай илтгэгч онцолж байна. Түүнчлэн гүтгэлгийг өөр нэр томъёогоор орлуулсан шинэ хууль тогтоомжийг оруулж ирэхийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.
55. Гүтгэлэг, түүнтэй холбоотой хэргийг эрүүгийн хуулиар шийдвэрлэхгүй байхыг дэмжих хандлага дэлхийн янз бүрийн хэсэгт ажиглагдаж байгаа нь сайшаалтай. Ийм ахиц дэвшил Латин Америкийн орнуудад илүү тод харагдаж байгаа бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчих бусад хэлбэрүүд байгаа хэдий ч

- гүтгэлгийг эрүүгийн гэмт хэрэгт хамаатуулах нь буурах хандлагатай байна. Хууль шинэчлэгдэж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээгүй байх хугацаанд хэвлэл мэдээллийн ажилтан болон бусад иргэнийг нэр төрд халдсан хэргээр хорихоос зайлсхийхийн тулд зохих хэмжээний торгууль оноох, өршөөл үзүүлэх зэргээр онцгой байдлын хууль тогтоомжийг тогтоомж хэрэгжүүлэх нь зохистой.
56. Үүний зэрэгцээ бусад улс орнууд хэвлэлийн эрх чөлөөг ноцтойгоор хязгаарласан хууль эрх зүйн арга хэмжээ авахыг шаардаж, нэр төрд халдсан болон түүнтэй адилтгах гэмт хэрэг үйлдсэн сэтгүүлчдэд хорих ял зэрэг хатуу шийтгэл ногдуулсаар байна. Өмгөөлөгч хөлслөхийн тулд их хэмжээний мөнгө зарцуулж, их хэмжээний хохирол амсах сэтгүүлч бус хүмүүст ч ийм зохицуулалтыг хэрэглэж болох юм. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хүн төрөлхтний хөгжил дэвшлийн гол цөм нь зохиолч юм.
57. Зохиолчид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хүн төрөлхтний хөгжил дэвшлийн гол цөм нь болж ирсэн. Тэд улс төр, эдийн засаг, шашны зонхилох элитүүдэд таалагдахгүй байр суурь, үзэл бодлыг дэвшүүлснийхээ төлөө цагдан хяналтын гол бай болдог нь гайхах зүйл биш юм. Олон оронд зохиолчдын амыг хаах, бусдад үг хэлэхээс сэрэмжлүүлэх зорилгоор урт хугацааны хорих ялыг оноодог. Тусгай илтгэгч 11-р сарын 15-ны өдрийг Шоронд хоригдож буй зохиолчдын өдөр болгон зарлах тухай Шорон дахь зохиолчдын хорооны санаачилгыг сайшаахыг хүсэж байна. Энэ төрлийн тайван арга хэмжээ нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр хангалттай мэдээлдэггүй асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулахад хувь нэмэр оруулах юм.

Д. Хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдал, хамгаалал

58. Тусгай илтгэгч сэтгүүлчдийг хөнөөх болон хүчирхийллийн бусад хэлбэрүүд нэмэгдэж, мэргэжлийн эрсдэл нь хүлээн зөвшөөрч боломгүй өндөр түвшинд хүрч буйд сэтгэл түгшиж байна. Сүүлийн 12 жилийн хугацаанд 1100 гаруй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан албан үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгджээ. Энэ эмгэнэлтэй тоо бол олон талын байр суурь, үзэл бодлын үндсэн дээр өөрийн гэсэн шийдвэр гаргах боломжийг олгож буй хараат бус, олон ургалч мэдээллийн төлөөс юм. Сэтгүүлчдийн эсрэг хүчирхийлэл нь мөн сэтгүүлчдийн гэр бүлийг хамарсан сэтгэл санааны болон бие махбодын дарамт, заналхийллийн олон тохиолдлуудаар өргөжиж байна.
59. 2006 оны 1-р сарын 1-ээс 12-р сарын 1-ний хооронд нэг зуун дөчин гурван хэвлэл мэдээллийн ажилтан амь үрэгдсэн бөгөөд эдний 31 нь туслах ажилтан байв. 36 нь Америк тивд, 32 нь Ази, Европ, Африкт 6, Ойрх Дорнодод 63. Энэ сүүлийн тоо бараг бүхэлдээ Ирак дахь мөргөлдөөнтэй холбоотой бөгөөд тухайн хугацаанд 59 хэвлэл мэдээллийн ажилтан амиа алдсан байна. 2006 оны арван нэгдүгээр сарын 23-ны байдлаар Иракт дайн эхэлснээс хойш 159 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан амь үрэгдсэн нь хэвлэл мэдээллийн хувьд хамгийн аюултай мөргөлдөөн болжээ. Тэдний дийлэнх нь Багдад дүүрэгт ажилладаг эрэгтэй иракчууд байв. Тухайн үед хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдлын асуудал гол асуудал байсан бусад улс орнуудад Мексик, Филиппин зэрэг улсаас тус бүр найман сэтгүүлч амиа алдсан байна. Мексикт сэтгүүлчдийн дийлэнх нь Оаксака хотод болсон эсэргүүцлийн жагсаалын дараа нас барсан бол Филиппинд сэтгүүлчдийн амь насыг хөнөөсөн шалтгаан нь улс төр, шашин шүтлэг, хууль бус бизнестэй холбоотой эрэн сурвалжилга байв. Шри Ланкад хэвлэл мэдээллийн зургаан ажилтан голдуу үндэстэн хоорондын мөргөлдөөний улмаас алагдсан байна.8
60. Тусгай илтгэгч Олон улсын хэвлэлийн хүрээлэнгийн 2006 оны 5-р сарын 29-ний өдрийн Ерөнхий ассамблей болон Олон улсын мэдээллийн аюулгүй байдлын хүрээлэнгээс баталсан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг хүний эрхийг зөрчсөн гэмт хэрэгтнүүдийг шүүхэд өгөх зохих арга хэмжээний талаар засгийн

газрууд хариуцах тухай тогтоолыг дэмжиж байна. Хэвлэл мэдээллийн байгууллагууд сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах амлалтаа чангатгаж, аюултай нөхцөл байдалд хамгийн зөв арга замаар ажлаа явуулах боломж олгохын тулд зохих арга хэмжээ авах ёстой гэсэн байр суурийг Тусгай илтгэгч мөн илэрхийлж байна.

61. Тусгай илтгэгч хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдлыг нэмэгдүүлэхийн тулд зарчим, дүрэм, таних тэмдэг батлах талаар төрөлжсөн институт, байгууллагуудын хүчин чармайлтыг өндрөөр үнэлж байна. Эдгээр санаачилгууд нь хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны цар хүрээг онцолж, тулгамдсан асуудлаар олон улсын түвшинд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх хэлэлцүүлэгт шинжээчийн түвшний хувь нэмэрийг оруулж буй юм. Үүнтэй холбогдуулан дайны болон мөргөлдөөнтэй бүс нутагт ажиллаж буй хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдлын талаарх удирдамжийг Ерөнхий Ассамблейгаас батлах нь олон улсын хамтын нийгэмлэгт үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх олон улсын баримт бичгийг өгөх боломжтой гэж Тусгай илтгэгч үзэж байна¹⁰. Одоогийн байдлаар хамгийн түрүүнд хийх ажил бол Зөвлөлд уг үзэгдлийн талаар иж бүрэн бөгөөд бодитой дүн шинжилгээ хийх, тэр дундаа эцсийн шийдэлд шуурхай хандах хэд хэдэн боломжит хувилбаруудыг санал болгох судалгааг бэлтгэх явдал юм.
62. Ийм судалгаанд дараах асуудлууд багтаж болно: хэвлэл мэдээллийн ажилтнуудын олон улсын хамгаалалт, аюултай бүсэд үүрэг гүйцэтгэж байх үед сэтгүүлчдийн эрх зүйн байдал; тэдний эсрэг хүчирхийллийн үндсэн шалтгаанууд; Төрийн хариуцлага, хувь хүний хариуцлага, тэдгээрийн аюулгүй байдал, аюулгүй байдлыг хэвлэл мэдээллийн байгууллага, үндэсний болон олон улсын эрх бүхий байгууллага, мэргэжлийн байгууллагуудын санаачилгаар сайжруулах арга зам; албан үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдсэн хэвлэл мэдээллийн ажилтнуудын ар гэрийнхэнд нөхөн олговор олгох сайн дурын сан байгуулах гэх мэт.
63. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон мэргэжлийн үйл ажиллагааны улмаас амь үрэгдсэн хэвлэл мэдээллийн ажилтнуудын төрөл төрөгсдөд зориулсан тусламжийн сан байгуулах нь олон улсын эв нэгдлийн ач холбогдлыг өндөрсгөхийн зэрэгцээ НҮБ-ын ивээл дор сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хүний эрхийн гол асуудал болгоход тус дэм болох юм хэмээн Тусгай илтгэгч үзэж байна.¹¹ Засгийн газар, засгийн газар хоорондын болон бүс нутгийн байгууллага, институт, түүнчлэн төрийн бус байгууллага, хувь хүмүүс, ажил үүргээ гүйцэтгэж яваад мэргэжлийн үйл ажиллагааны улмаас амиа алдсан хэвлэл мэдээллийн ажилтнуудын төрөл төрөгсөд ийм тусламжийн санг байгуулахад хамтран ажиллаж болно. Энэ төрлийн дэмжлэгийг голчлон хөгжиж буй орнуудад амьдарч буй санхүүгийн эх үүсвэргүй гэр бүлүүдэд эв санааны нэгдлийн илэрхийлэл болгон үзүүлж, гэр бүлийн гишүүн нь нас барсны улмаас орлогын хомсдолыг арилгахад чиглэнэ. Ийм сангийн үйл ажиллагааны дүрэм, арга барилыг НҮБ-ын тогтолцооны хүрээнд байгуулагдсан ижил төстэй байгууллагууд боловсруулж, асран хамгаалагчдын зөвлөлд өндөр ёс суртахуунтай, шударга, энэ үзэгдлийн талаар мэргэшсэн хүмүүсийг багтаасан байх ёстой.

II. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

A. Дүгнэлт

- 64 Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хамгийн идэвхтэй эх сурвалж болох сэтгүүлч, үйлдвэрчний эвлэлийнхэн, нийгмийн ажилтан, оюутнууд болон багш, зохиолч, уран бүтээлчдийг дарангуйлах арга барил дэлхийн янз бүрийн улс оронд ижил төстэй

байдаг. Үүнд хүний амь насыг хөнөөх, хүчээр алга болгох, дур зоргоороо баривчлах, цагдан хорих, зүй бусаар харьцах, заналхийлэх, дарамтлах, шударга бус шүүх хурал хийх, шүүх, захиргааны арга хэмжээ авах зэрэг багтаж байна. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлж буй эмэгтэйчүүд болон цөөнхийн бүлгүүд эрх баригчдын нэмэлт дарамтад өртөж болзошгүй. Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг зөрчих арга хэрэгсэл үндсэндээ өөрчлөгдөөгүй хэвээр байгаа ч Тусгай илтгэгч Интернэт хэрэглэгчдийн эсрэг зөрчил ихээхэн нэмэгдсэнийг тэмдэглэжээ. Хэвлэл мэдээллийн салбарынхан Иракийн мөргөлдөөний улмаас хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдал, хамгааллын талаар улам бүр санаа зовниж, амь насаа алдсан хүмүүсийн тоо улам дордож байгаа бололтой.

65 Тусгай илтгэгч хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг хүчирхийллийн дуусашгүй тойрог, тэр дундаа хүн амины халдлагад сэтгэл түгшиж байна. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлсний төлөө олон янзын, хууль ёсны болон хууль бус ашиг сонирхол бүхий түрэмгийлэгчдийн бай болж байна. Зэвсэгт бүлэглэлүүд, тэр дундаа үндэсний арми, хууль сахиулах байгууллагууд, эдийн засгийн корпорациудын үйлддэг халдлагууд хэвээр байна.

66 Засгийн газар, төрийн байгууллагууд нь иргэдийн, тэр дундаа хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангах үндсэн үүрэгтэй. Хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдал, хамгаалалтыг хамарсан олон улсын эрх зүйн хэм хэмжээг бий болгох нь олон улсын хүний эрхийн нийгэмлэгээс авах хийх тулгамдсан хариу үйлдэл мөн. Хуулийн хариуцлагын аливаа хэлбэрээс зугтдаг гэмт этгээдүүд ял шийтгэлгүй үлддэг нь хараат бус, олон ургалч мэдээллийн хөгжилд саад болж байна. Хариу үйлдэл хийхгүй байх, хайхрамжгүй хандах, гэмт хэргийн этгээдтэй тохиролцох зэрэг нь хүний эрхийг зөрчиж буй хэлбэр гэж үзэж болно.

67 Өмнөх жилүүдэд дурдсанчлан, өнөөгийн олон улсын нөхцөл байдал нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд сөргөөр нөлөөлж байна. Хэд хэдэн засгийн газар терроризмоос урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг баталсан бөгөөд эдгээрээс зарим нь олон улсын хүний эрхийн хууль тогтоомжоор хориглосон зүйлсийг дахин сэргээхэд хүргэж болзошгүй байна. 12 Ийм хууль тогтоомж, ялангуяа хэвлэл мэдээллийн байгууллагуудыг хаах, хэвлэлийн агуулгад цензур тавих, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг баривчлах хорих арга хэмжээ авах зэрэг нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд сөргөөр нөлөөлж байгааг Тусгай илтгэгч тэмдэглэж байна. Түүнчлэн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний талаар ч ижил зүйл хэлж болохоор байна. ҮЭ, оюутны бүлгүүд, нийгэм, соёлын эвсэл хөдөлгөөн, сэхээтнүүд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан хууль тогтоомжийн хэрэгжилтээс болж хохирч байна.

68 Хэвлэл мэдээлэл нь мэтгэлцээн, санал бодлоо солилцох талбарын хувьд нийгэмд амин чухал үүрэг гүйцэтгэдэг. Олон оронд хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, ялангуяа олон нийтийн ашиг сонирхлын маргаантай сэдвээр мэтгэлцэх эрх чөлөөг хамгаалсан хэм хэмжээ, хууль журмаар баталгаажуулсан байдаг. Ёс зүйн дүрэм байх нь сэтгүүлчид олон үзэл бодол, байр суурийг иргэдэд хүргэж, явдал, нөхцөл байдлын мөн чанарыг ойлгоход нь тус болохын тулд дүнтэй ажиллахад түлхэц болж байна.¹³

69 Хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсад үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэхийн тулд шударга, оновчтой, хариуцлагын мэдрэмжтэй ажиллах шаардлагатай. Шашин шүтлэг, гүн гүнзгий итгэл үнэмшил, угсаатны өвөрмөц байдлыг хэвшмэл ойлголтоор тодорхойлох, гутаан доромжлох зэргээр нь янз бүрийн бүлгүүдийн хооронд бүтээлч, тайван яриа хэлэлцээ өрнүүлэх таатай орчинд сөргөөр нөлөөлдөг. Гажуудсан яриа хэлэлцүүлэгт тулгуурласан туйлшрал нь үндэстэн ястны болон шашны үзэн ядалтыг түгээн дэлгэрүүлж улмаар олон үндэстний эв нэгдэлтэй нийгмийг нэгтгэх уйгагүй хүчин чармайлтын үр дүнд бий болгосон нийгэм, соёлын нарийн тэнцвэрт байдлыг алдагдуулж байна. Сэтгүүлчдийн эвлэл холбоод нь шашны асуудал гэх мэт

маргаантай сэдвээр мэргэжлийн хүмүүсийн мэтгэлцээн өрнүүлэх замаар тухайн сэдвээр гүнзгий дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх ёстой.

70 Шашин шүтэх эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зарчмууд өөр хоорондоо зөрчилдөх ёсгүй. Эдгээр нь нийгэм, хүн амын хүмүүнлэгийн болон оюун санааны үндсийг харилцан бэхжүүлж, сайжруулдаг. Шашны итгэл үнэмшлийг хүндэтгэх явдал хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй зөрчилдөх бус зохицолдож тухайн нийгэм, соёлын нөхцөлд өөрийн тэнцвэрийг олох ёстой.

71. Мэдээлэл, үзэл бодлын чөлөөт урсгал нь янз бүрийн ард түмэн, соёлын хоорондох урам зориг, харилцааны эх сурвалж болж буй учир ялангуяа дэлхийн хэмжээнд мэдээллийн хүртээмж эрс нэмэгдэж буй өнөө цаг үед энэхүү урсгалыг дэмжих нь зүйн хэрэг юм.

Хүчирхийлэлгүйгээр үзэл бодлоо амаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр эсвэл зөвшөөрөгдсөн бусад хэрэгслээр илэрхийлэхийг дэмжих ёстой.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэх нь онцгой үүрэг, хариуцлагыг дагуулдаг тул бусад хүмүүсийн эрхийг хүндэтгэхийг баталгаажуулахын тулд цөөн хэдэн хязгаарлалттай байж болно. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу ийм хязгаарлалтын мөн чанарыг тодорхой байлгахын тулд зөвхөн хуулиар тогтоох ёстой.

Түүнчлэн, 3-р зүйлд эдгээр хязгаарлалтыг ямар тохиолдолд хэрэглэж болохыг тодорхой зааж өгсөн: (а) бусдын эрх, нэр хүндийг хүндэтгэх; (б) үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журам, эсвэл нийгмийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зорилгоор. Ийм хязгаарлалтыг зөвхөн ардчилсан дэг журамд онцгой аюул учирсан тохиолдолд хэрэглэх ёстой бөгөөд тодорхой хугацаатай байх ёстой. 3 (а)-д дурдсан хязгаарлалтын хувьд хүний эрхийг хүндэтгэх болон бусдын нэр хүнд, хувийн нууцыг хамгаалах эрхийг хэрэгжүүлэхдээ чухал үнэ цэнтэй сэдвээр мэтгэлцээнд саад учруулахгүй, бусдыг доромжлохгүйгээр хэрэгжүүлэх ёстой.

72 Шинэ технологийн тухай хууль тогтоомжид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалдаг улс орнуудад ч ихээхэн анхаарал хандуулж байна. Харамсалтай нь шинэ болон хуучин технологиудыг улс төрийн суртал ухуулгын боловсронгуй хэрэгсэл болгон ашиглаж байгаа нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, үзэн ядах үзэл санааны туйлшрал, угсаатны хурцадмал байдлыг дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулсаар байна. Гэсэн хэдий ч харилцаа холбоо, мэдээллийн шинэ хэрэгсэл бүх нийтэд хүртээмжтэй байх нь нийгмийн хөгжил дэвшил, боловсрол, мэдлэгийг түгээхэд ихээхэн түлхэц өгч, улмаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хүрээг өргөжүүлэх боломжтой. Харилцаа холбооны шинэ технологи нь мэдээлэл олж авах эрх болон хувийн нууцыг хамгаалах эрхийн хоорондох зааг хязгаарын талаар томоохон маргаан үүсгээд байна.

73 Интернэтийн засаглал ба хүний эрх нь ойрын ирээдүйд олон улсын хамтын нийгэмлэгийн яриа хэлэлцээрийг хөдөлгөөнд оруулах сэдвүүдийн нэг юм. Интернэтийн засаглал нь хүний эрхийн үзэл баримтлалд тууштай суурилах ёстой. Интернэт болон бусад харилцааны шинэ хэрэгслээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулах нь дэлхий даяарх ядуурлын эсрэг тэмцлийн стратегийн бүрэлдэхүүн хэсэг юм. Шинэ технологийг дэлхий даяар ашиглах боломжтой болгосноор хөгжингүй болон хөгжиж буй орнуудын нийгэм, эдийн засгийн ялгааг багасгахад хувь нэмэр оруулна.

74 Интернэтээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь зөвхөн арилжааны ашиг сонирхлоос хамаарах ёсгүй. Эдийн засгийн хүчнүүд хүний эрх, шударга ёс, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахыг уриалсан иргэний нийгмийн найдвартай түнш байх учиртай. Нөгөөтэйгүүр, хэрэглэгчдийн үйлдлүүдийг зохион байгуулалттайгаар хянах нь хувийн нууцыг хамгаалах эрхийг зөрчиж буйн тодорхой хэлбэр бөгөөд бие даан сонголт хийх чадварыг нь гуйвуулж, улмаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нь хязгаарлаж байна.

75 Гүтгэлгийг эрүүгийн хуулиар шийдвэрлэхгүй байх чиг хандлага өсөн нэмэгдэж буйг Тусгай илтгэгч сайшаан дэмжиж байгаа. Энэ ангиллын хэргийг иргэний хуулиар зохицуулсан шинэ хууль тогтоомж баталсан улс орнуудын тоо нэмэгдэж байна. Харамсалтай нь гүтгэсэн, доромжилсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хорих ял оноох, их хэмжээний торгууль ногдуулах явдал бусад олон оронд түгээмэл хэвээр байна.

В. Зөвлөмж

76 Тусгай илтгэгч үг хэлэх, үзэл бодлоо эрх чөлөөний бүх хэлбэртэй холбоотой үндэсний хууль тогтоомж, шүүхийн практикийг олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, дүрэм журамд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд үнэлж, шаардлагатай үед шинэчлэлийн үйл явцыг эхлүүлэхийг Засгийн газруудад уриалж байна. Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөөний салбарт байнгын ахиц дэвшил гаргахын тулд хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хамгаалах, дэмжих асуудлыг нэн тэргүүний зорилт болгон авч үзэхийг Тусгай илтгэгч засгийн газруудад мөн зөвлөж байна.

77 Тусгай илтгэгч Хүний эрхийн зөвлөлийг хоёр дахь чуулганаар танилцуулсан шашин шүтлэг, итгэл үнэмшлийн эрх чөлөөний асуудлаарх Тусгай илтгэгч болон арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн орчин үеийн хэлбэрүүдийн асуудлаарх Тусгай илтгэгч нарын шашин шүтлэгийг гутаан доромжлох, шашны үзэн ядалтыг өдөөх асуудалд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, харийн үзэн ядалт болон түүнтэй холбоотой үл тэвчих тухай хамтарсан илтгэлийн (A/HRC/2/3) зөвлөмжийг нээлттэй хэлэлцэхийг урьж байна. Энэхүү тайланд янз бүрийн шашин шүтлэг, соёл иргэншил энх тайвнаар зэрэгцэн орших эрэл хайгуулд тэнцвэртэй хандахыг дэмжих зорилгоор Зөвлөлийн цаашдын үйл ажиллагааны зөвлөмж, дүгнэлтийг багтаасан болно.

78 Тусгай илтгэгч хараат бус хэвлэл мэдээллийн байгууллага, салбарын эвлэл холбоодыг шашин шүтлэгийг гутаан доромжлох, үндэстэн ястны болон бусад эмзэг бүлгийг ялгаварлан гадуурхах шинжтэй илэрхийллийн хэлбэрт сонор сэрэмжтэй байхыг уриалж байна. Эмэгтэйчүүд, цөөнх болон бусад бүлгүүд, ялангуяа цагаачид болон орогнол хүсэгчдийг ялгаварлан гадуурхах үг хэллэг хэрэглэх нь олон нийтийн хэлэлцүүлэгт эрсдэл учруулж, өөрийн цензур, айдас түгшүүрийг өдөөдөг. Эдгээр илэрхийллийн хэлбэр нь сэтгүүл зүйн чанар, нэр хүндэд сөргөөр нөлөөлж, эцсийн дүндээ хэвлэл мэдээллийн шударга байдлыг алдагдуулж байна. Үүнтэй холбогдуулан хэвлэл мэдээллийн байгууллагууд мэргэжлийн ёс зүй, хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлэх үүднээс шаардлагатай бол НҮБ-ын холбогдох байгууллага болон бусад шинжээчдийн байгууллагын туслалцаатайгаар гишүүддээ хүний эрхийн сургалтыг системтэйгээр зохион байгуулах ёстой. Хэвлэл мэдээллийн холбоод нийгмийн хамгийн эмзэг асуудлуудыг мэргэжлийн форумар байнга хэлэлцэж байх ёстой.

79 Аливаа улсын засгийн газраас болон засгийн газар хоорондоос шинээр бий болгосон Интернэтийг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь удирдах үүрэг бүхий байгууллага нь хүний эрхийн үзэл баримтлалд тулгуурлах ёстойг Тусгай илтгэгч тууштай онцолж байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19-р зүйлд тодорхойлсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн тухай заалт болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүний болон ард түмний эрхийн тухай Африкийн дүрэм, Хүний эрхийн тухай Америкийн конвенц, Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенц зэрэг хүний эрхийн бусад баримт бичиг нь засгийн газар болон олон улсын хамтын нийгэмлэгийн хүчин чармайлтыг ерөнхийд нь чиглүүлэх ёстой.

- 80 Тусгай илтгэгч бүх улс орнуудад Интернэтэд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулахдаа цахим орчинд мэдээлэл түгээгч вэб сайт, блогчдод хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдтэй адил эрх зүйн хамгаалалтад хамруулахыг уриалж байна. Олон нийтийн яриа, хэлэлцүүлгийг баяжуулахын тулд ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг дэмжих нь чухал. Интернэт үйлчилгээ үзүүлэгч болон вэбсайтыг тухайн улс орны эрх бүхий байгууллагад бүртгүүлэхэд садар самуунаас хүүхдийг хамгаалах хууль тогтоомжийн холбогдох заалтаас өөр ямар нэгэн тусгай шаардлага тавих ёсгүй. Түүнчлэн, ялангуяа буурай хөгжилтэй бүс нутагт боловсрол, мэдлэгийг түгээх зорилгоор шинэ технологийн бүх нийтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засаг, арилжааны үүднээс Интернэтийн засаглалыг хязгаарлахгүй байхад анхаарах ёстой.
- 81 Тусгай илтгэгч гүтгэлэг болон түүнтэй адилтгах хэргийг эрүүгийн хуулиар шийдвэрлэхгүй байхыг засгийн газруудад хатуу зөвлөж байна. Эдгээрийг иргэний хуулийн дагуу шийдвэрлэх ёстой. Нөхөн олговорт төлөх торгуулийн хэмжээ нь зохистой байх бөгөөд мэргэжлийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжийг хязгаарлах ёсгүй. Тусгай илтгэгч мөн хэвлэл мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагааны улмаас баривчлагдсан бүх сэтгүүлчдийг нэн даруй, ямар ч болзолгүйгээр суллахыг засгийн газруудад уриалж байна. Бусдын нэр төрд халдах, гүтгэх хэрэгт хорих ял оноох ёсгүй.
- 82 Мөн засгийн газрууд худал мэдээлэл тараах гэх мэт хуулийн өөр нэр томъёог ашиглан гүтгэлгийн тухай хуультай ижил зорилготой шинэ хэм хэмжээг нэвтрүүлэхээс татгалзах хэрэгтэй. Ямар ч тохиолдолд улс үндэстэн, түүний бэлгэдэл, Засгийн газар, гишүүд, тэдний үйлдлийг шүүмжлэхийг гэмт хэрэг хэмээн үзэж болохгүй. Сонгуульт албан тушаалтнууд болон бусад эрх баригчид өөрсдийн чиг үүргийн дагуу албан үүргээ хэрэгжүүлэхдээ хэвлэлийн анхаарлыг татаж болзошгүйг ухамсарлах ёстой. Нөгөөтэйгүүр, засгийн газраас мэдээлэл олж авах эрхийг хязгаарлахгүйгээр, ялангуяа гэр бүлийн амьдрал, насанд хүрээгүй хүмүүсийн хувийн нууцыг хамгаалах эрхийг хангалттай хамгаалж, төрийн үйл хэргийг ил тод, ардчилсан хяналтад байлгахад хувь нэмэр оруулах ёстой.
- 83 Энэ хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцаж болох харилцаа холбооны асуудал эрхэлсэн бие даасан байгууллага бий болгож, холбогдох чиглэлээр зохих туршлагатай хүмүүсийг ажиллуулах, мөн хэвлэл мэдээллийн хэрэг, зөрчлийн талаар эвлэрүүлэн зуучлагчийн чиг үүрэг бүхий хэвлэл омбудсменийг томилж ажиллуулахыг Тусгай илтгэгч Засгийн газруудад уриалж байна. Эдгээр нь аливаа зөрчлийг шударгаар үнэлж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үндсэн үнэт зүйлсийг эрсдэлд оруулахгүйгээр зохих шийтгэлийг оногдуулах юм.
- 84 Харилцаа холбооны эрх бүхий ийм байгууллага, омбудсмэн буюу хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн хамтарсан үйл ажиллагаа нь эцсийн дүндээ эдийн засаг, улс төрийн бүлгүүдээс гадна иргэний нийгмийн янз бүрийн оролцогч, орон нутгийн болон цөөнхийн төлөөлөл, эмзэг бүлгийнхэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эрх чөлөөгөө эдлэх боломжийг хангаж ажиллана. Энэхүү байгууллага нь мэдээллийн зах зээл дэх эдийн засгийн оролцогч талуудын үйл ажиллагааны өрсөлдөөнд хяналт тавих эрх мэдэлтэй байх ёстой. Иргэд хувийн болон төрийн ноёрхлын сөрөг үр дагаварт өртөхгүйгээр сонголтоо хийх боломжтой байх ёстой. Тэдгээр сөрөг үр дагаварт мэдээллийн олон ургалч байдал ноцтойгоор алдагдах, хэвлэл мэдээллийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх, хүртээмжийн зардал нэмэгдэх зэрэг ордог. Нэмж дурдахад ноёрхлын дэглэм нь иргэдийн санал бодлыг хянах, цензурыг хэрэгжүүлэхэд хялбар болгодог бөгөөд үүний зэрэгцээ янз бүрийн салбарт иргэдийн сонголтыг ихэвчлэн далд хэлбэрээр чиглүүлж чаддаг.
- 85 Хэвлэл мэдээллийн аюулгүй байдал нь үзэл бодлын туйлшрал, өргөн хүрээтэй хүчирхийллийн цаг үед олон ургалч мэдээллийг баталгаажуулах үндсэн элементүүдийн нэг хэвээр байна. Засгийн газар, төрийн байгууллагууд шаардлагатай үед сэтгүүлчдэд хараат бус байдлаа хадгалан, хүлээн зөвшөөрөгдөхүйц аюулгүй байдлын түвшинд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжийг олгох түр хамгаалалтын схемийг бий болгох

ёстой. Хэвлэл мэдээллийн байгууллагууд мөн аюулд учирсан сэтгүүлчдийг уян хатан байдлаар хамгаалах зардлыг даах шийдвэр гаргаж болно. Сэтгүүлчдийн эсрэг халдлага үйлдэгчдийг илрүүлж зохих шийтгэл оногдуулах нь хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, жирийн иргэдийн төрийн байгууллагад итгэх итгэлийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулна. Эрсдэлд орсон хэвлэл мэдээллийн ажилтнууд ямар ч тохиолдолд сэтгэл санааны дарамтаас гадна биеэ хамгаалах, эдийн засгийн дарамтыг үүрэх ёсгүй. Засгийн газар мөн үйлдвэрчний эвлэлийн ажилтан, нийгмийн ажилтан, оюутан, багш, уран бүтээлч зэрэг эрсдэлтэй бусад бүлгийг хамгаалах үүрэгтэй.

86 Тусгай илтгэгч сэтгүүлчдийн аюулгүй байдал, хамгааллын асуудал, ялангуяа зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдалд анхаарал хандуулахыг Хүний эрхийн зөвлөлд дахин уриалж байна. Зөвлөл өмнө нь ярилцсанчлан хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг хүчирхийллийн шалтгааны талаарх иж бүрэн дүгнэлт, зөвлөмжийг багтаасан судалгааг бэлтгэх даалгаврыг Илтгэгчид өгч болох юм. Энэхүү судалгаа нь Хүний эрхийн зөвлөлийн хүрээнд энэхүү чухал асуудлаарх мэтгэлцээний эхний алхам болох юм.

Эх сурвалж, тайлбар

- 4 On this matter see: The Information Economy Report 2006: The Development Perspective, UNCTAD/SDTE/ECB/2006/1 (16/11/2006).
- 5 Concluding observations of the Human Rights Committee, Mexico, United Nations document CCPR/C/79/Add.109, paragraph 19. See also the comments by the Government of Mexico on the concluding observations of the Human Rights Committee, CCPR/C/79/Add.123 (2000). The Human Rights Committee also welcomed the amendment of the criminal code eliminating the crime of defamation of the Republic [of Slovakia] and its representatives, concluding observations of the Human Rights Committee, CCPR/CO/78/SVK(2003).
- 6 See Principle 10 of the Declaration of Principles on Freedom of Expression (also known as the Chapultepec Declaration) approved by the Inter-American Commission on Human Rights at its 108 regular session (1994). See also point XII, resolution on the Adoption of the Declaration of Principles on Freedom of Expression in Africa (2002), African Commission on Human and Peoples' Rights/Res. 62 (XXXII)02.
- 7 International Federation of Journalists, see www.ifj.org.
- 8 International News Safety Institute, see www.newssafety.com. In addition, other major organizations like the Committee for the Protection of Journalists (see www.cpj.org) and Reporters Sans Frontières (www.rsf.org) provide reliable statistics concerning media professional casualties. Differences are generally due to the possible inclusion or exclusion of figures concerning media support staff - drivers, interpreters - or media professionals other than journalists and reporters, mainly cameramen, soundmen, photographers. Freelance journalists are more difficult to track than professionals working for a media company.
- 9 International News Safety Institute, Protection of Journalists in conflict - Fundamental Rules - Brussels, 7 August 2006, see <http://www.newssafety.com/stories/insi/conflictrules.htm>.

Reporters without Borders, Charter for the safety of journalists working in war zones or dangerous areas, Paris 2002, see http://www.rsf.org/print.php3?id_article=2350.

For the Press Emblem initiative and the Media Casualties Ticking Clock, see

- 10** See First Additional Protocol to the Geneva Conventions of 12 August 1949, relating to the Protection of Victims of International Armed Conflicts, section III, chapter III, Journalists, article 79. Measures of protection for journalists (1) Journalists engaged in dangerous professional missions in areas of armed conflict shall be considered as civilians within the meaning of article 50, paragraph 1. (2) They shall be protected as such under the Conventions and this Protocol, provided that they take no action adversely affecting their status as civilians, and without prejudice to the right of war correspondents accredited to the armed forces to the status provided for in article 4 A (4) of the Third Convention. (3) They may obtain an identity card similar to the model in annex II of this Protocol. This card, which shall be issued by the Government of the State of which the journalist is a national or in whose territory he resides or in which the news medium employing him is located, shall attest to his status as a journalist.
- 11** A number of media organizations run safety programmes and funds. In addition to those already mentioned, see also International Federation of Journalists Safety Fund, which also help with medical and legal assistance, and travel. International Pen runs a PEN Emergency Fund, which raises funds for imprisoned, or otherwise threatened, writers and journalists (www.internationalpen.org.uk).
-
- 12** See the Annex of the present report.
- 13** The Five Fault Lines by the late Robert C. Maynard are an excellent example of rationalization of this problem, see <http://www.maynardije.org/programs/faultlines/>.